



**НИЙСЛЭЛИЙН  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 01 өдөр

Дугаар М09

Улаанбаатар хот

Бүтэц орон тоо, албан тушаалын  
чиг үүрэг, цалингийн сүлжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/757 дугаар захирамж, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын бүтэц, орон тоог 1 дүгээр, албан тушаалын чиг үүргийг 2 дугаар, цалингийн сүлжээг 3 дугаар, ажилтан албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинэчлэн баталсан цалингийн сүлжээнд үндэслэн ажилтнуудад цалинг бодож олгохыг нягтлан бодогч (Л.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Газрын даргын энэ тушаалыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”  
ОНӨТҮГ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 01-ний  
өдрийн А/09 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт




“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Албан тушаал	Орон тоо
01	Дарга	1
ЗАХИРГААНЫ АЛБА		
02	Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн	1
03	Хуулийн зөвлөх	1
04	Нягтлан бодогч	1
05	Гадаад харилцаа, бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн	1
06	Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн	1
07	Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	1
08	Нярав-үйлчлэгч	1
09	Жолооч	1
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБА		
10	Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн	1
11	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	1
12	Үйлдвэрлэл, технологийн эрчим хүч, кластер инженер	1
13	Төсөл, хөрөнгө оруулалтын эдийн засагч	1
14	Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер	1



“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”  
ОНӨТҮГ-ын 2023 оны 07 дугаар сарын 01-ний  
өдрийн А/09 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт




“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

д/д	Албан тушаал	Орон тоо	Чиг үүрэг
01	Дарга	1	Байгууллагын бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд удирдлагаар хангаж ажиллах
<b>ЗАХИРГААНЫ АЛБА</b>			
02	Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн	1	-Албаны өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу удирдлагаар хангаж ажиллах, албаны ажлын гүйцэтгэл, үр дүнг бүхэлд нь хариуцах -Байгууллагын үйл ажиллагааны оны төлөвлөлт, тайлангийн нэгтгэл хариуцах, -Паркийн нэгжүүдтэй холбоотой Захиргааны чиглэлийн өдөр тутмын шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх, -Хүний нөөцийн менежментийн бүх чиг үүргүүдийг хэрэгжүүлэх
03	Хуулийн зөвлөх	1	-Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн хуулийн хэрэгжилт, хяналт, гэрээ хэлцэл -Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ажил хэргийг удирдлагын үүрэг даалгавар, удирдамжийн дагуу нийслэл хотод эрхлэх
04	Нягтлан бодогч	1	Байгууллагын санхүү, Нягтлан бодох бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх
05	Гадаад харилцаа, бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн	1	-Байгууллагын бичиг хэрэг, архивын бүхий л үйл ажиллагаа, -Байгууллагын Гадаад харилцаатай холбоотой бүх чиг үүргүүд, -Иргэн, ААНБ-уудаас ирүүлэх өргөдөл, гомдол, саналыг хүлээн авах, бүртгэлжүүлэх, шийдвэрлүүлэх, хариу хүргүүлэх, -Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтын бүртгэл хөтлөх, тайлагнах бүхий л ажиллагааг хариуцан гүйцэтгэх
06	Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн	1	-Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах маркетингийн бүхий л үйл ажиллагаа /Хөрөнгө оруулагч нартай уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах, сургалт сурталчилгаа хийх/, -Байгууллагын олон нийттэй харилцах харилцааг хамаарах
07	Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	1	-Байгууллагын программ хангамжийн боловсруулалт, ашиглалт, хамгаалалт, сервер үйлчилгээ, -Мэдээллийн сангийн бүртгэл, -Сурталчилгааны материалын эх бэлтгэл, хэвлэл
08	Нярав-үйлчлэгч	1	-Байгууллагын аж ахуй, эд хөрөнгө бүртгэл, хамгаалалтыг хариуцах, -Байгууллагад хэрэгцээтэй хангамж, нийлүүлэлт -Дотоод үйлчилгээ /оффисын цэвэр цэмцгэр байдал, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх/

09	Жолооч	1	Жолоочийн бүхий л үүрэг хариуцлагыг хамаарах
<b>ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБА</b>			
10	Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн	1	-Албаны өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу удирдлагаар хангаж ажиллах, албаны ажлын гүйцэтгэл, үр дүнг бүхэлд нь хариуцах -Байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнг бүхэлд нь хариуцах -Төслүүдийн ТЭЗҮ-д техникийн ба технологи, инженерчлэлийн судалгаа, дүгнэлт хийх -Төслүүдийн инновацийн бодлогыг хамаарах -Паркийн нэгжүүдтэй холбоотой үйлдвэрлэл, технологийн чиглэлийн өдөр тутмын шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх
11	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	1	-Паркийн ХЕТ-ний хэрэгжилт, хяналт -Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, ашиглалт, хяналт
12	Үйлдвэрлэл, технологийн эрчим хүч, кластер инженер	1	-Паркийн эрчим хүчний хангамжийн кластер, бүтэц -Эрчим хүчний бүтээн байгуулалтын хяналт-үнэлгээ
13	Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер	1	-Паркийн эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци, инкубатор төвийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцах -Шинэ төслүүдэд шинжлэх ухааны үндэслэл, хэрэгжүүлэх боломж ба эрсдэлийг үнэлэх -ЖДҮ-ийг дэмжих хөгжүүлэх төслүүдийг зохион бүтээх, нэвтрүүлэх үйл ажиллагаа
14	Төсөл, хөрөнгө оруулалтын эдийн засагч	1	- Паркийн нэгжүүдийн төслүүдэд эдийн засгийн үр өгөөжийн шинжилгээ, дүгнэлт -Шинэ төслүүдийн хөрөнгө оруулалтын тооцоолол, дүгнэлт -Паркийн хөгжлийн дунд ба урт хугацааны төлөвлөлтийн эдийн засгийн тооцоолол -Паркийн нэгжүүдэд үзүүлэх татварын хөнгөлөлттэй холбоотой бодлогын хэрэгжилтийг хамаарах -Концессын бодлогыг хамаарах




“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”  
ОНӨТҮГ-ын даргын 2023 оны 07 сарын 01-ний  
өдрийн А/09 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
БҮТЭЦ, ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

д/д	Албан тушаал	Орон тоо	Үндсэн цалин
01	Дарга	1	1,500,000
02	Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн	1	1,114,000
03	Хуулийн зөвлөх	1	1,053,000
04	Нягтлан бодогч	1	1,114,000
05	Гадаад харилцаа, бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн	1	1,053,000
06	Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн	1	1,053,000
07	Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	1	1,053,000
08	Нярав-үйлчлэгч	1	868,000
09	Жолооч	1	827,000
10	Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн	1	1,114,000
11	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	1	1,053,000
12	Үйлдвэрлэл, технологийн эрчим хүч, кластер инженер	1	1,053,000
13	Төсөл, хөрөнгө оруулалтын эдийн засагч	1	1,114,000
14	Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер	1	1,053,000

Багануур үйлдвэрлэл, технологийн парк  
ОНӨТҮГ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 01-ний  
өдрийн А/09 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт



АЖИЛТАН АЛБАН ХААГЧДАД ОЛГОХ  
ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

д/д	Албан тушаал	Төрийн алба хаасан хугацаа/жил	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох хувь
01	Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн	36	25%
02	Хуулийн зөвлөх	41	25%
03	Нягтлан бодогч	39	25%
04	Гадаад харилцаа, бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн	7,1	7%
05	Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн	-	-
06	Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	3,7	3%
07	Нярав-үйлчлэгч	3,4	3%
08	Жолооч	2,8	2%
09	Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн	6,9	6%
10	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	-	-
11	Үйлдвэрлэл, технологийн эрчим хүч, кластер инженер	12	11%
12	Төсөл, хөрөнгө оруулалтын эдийн засагч	3	2%
13	Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер	-	-